

Цорын ганц зам (The only way)

Бид Бурханы өмнө хэн бэ?

Бүгд нүгэл үйлдсэнээр Бурханы алдарт хүрдэггүй... (Ром 3:23)

Учир нь нүглийн хөлс бол үхэл, харин Бурханы бэлэг бол бидний Эзэн Христ
Есүс доторх мөнх амь мөн. (Ром 6:23)

Есүс энэ дэлхийд ирэх болсон зорилго юу вэ?

Түүний цусанд итгэх итгэлээр дамжуулан Бурхан Түүнийг эвлэрүүлэл гэж
нийтэд харуулав. Ингэсэн нь Бурхан урьд нь үйлдэгдсэн нүглүүдийг тэвчин
өнгөрүүлсэн учраас Өөрийнхөө зөвийг илэрхийлэхийн тулд байсан... (Ром 3:25)

Бид үргэлжлүүлэн гэм үйлдсээр байвал бид яах вэ?

Нүгэл үйлддэг нэгэн нь диаволынх юм. Диавол эхнээсээ нүгэл үйлдсэн.
Диаволын үйлсийг устгахын тулд Бурханы Хүү энэ зорилгын төлөө үзэгджээ. (1
Иохан 3:8)

Нүгэл үйлддэг хүн бүр бас ёс бус хэрэг үйлддэг. Нүгэл бол ёс бус хэрэг юм. (1
Иохан 3:4)

Хэн Бурханы хүүхэд вэ? Харин хэн нь диаволын хүүхэд вэ?

Бурханы хүүхдүүд ба диаволын хүүхдүүд үүгээр танигддаг юм. Зөвийг
үйлддэггүй аливаа хүн Бурханых биш. Ах дүүгээ хайрладаггүй нэгэн нь ч
Бурханых биш. (1 Иохан 3:10)

Гэм хийхгүй байх арга зам бий юу?

Бурханаас төрөгч ямар ч хүн нүгэл үйлддэггүй. Учир нь Бурханы үр түүний
дотор байгаа. Тэр хүн Бурханаас төрсөн тул нүгэл үйлдэж чаддаггүй. (1 Иохан
3:9)

Бид яагад дахин төрөх ёстой байдаг вэ?

Есүс хариуд нь

—Үнэнээр, үнэнээр Би чамд хэлье. Хэн дээрээс эс төрнө, тэр хүн Бурханы

хаанчлалыг үзэж чадахгүй...

Махан биеэс төрсөн нь махан бие, Сүнснээс төрсөн нь сүнс болой. (Иохан 3:3,6)

Есүс мөнх амийн талаар юу гэж хэлсэн бэ?

Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Миний үгийг сонсоод, Намайг илгээгч Түүнд итгэгч нь мөнх амьтай болох бөгөөд яллагдахгүй. Харин үхлээс өнгөрч амь уруу шилжив. (Иохан 5:24)

Бид мөнх амьтай гэдгээ хэрхэн батлаж чадах вэ?

Бид ах дүүсээ хайрладаг учраас үхлээс амь уруу шилжсэнээ мэднэ. Үл хайрлагч нь үхлийн дотор байна. (1 Иохан 3:14)

Мөнх амьтай болох цорын ганц арга зам юу вэ?

Есүс

—Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй.

(Иохан 14:6)

Үнэнээр, үнэнээр Би та нарт хэлье. Итгэдэг хүн мөнх амьтай. (Иохан 6:47)

Бид Бурханы хүүхдүүд хэрхэн болж чадах вэ?

Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрэнд итгэдэг хүмүүст Бурханы хүүхэд болох эрхийг Тэр өгөв.

Тэд цусаар биш, махан биеийн хүслээр ч биш, хүний хүслээр ч биш, харин Бурханаар төрөгсөд билээ. (Иохан 1:12,13)

Та Есүсийг өөрийн амьдралдаа хүлээн авахыг хүсвэл дараах залбиралыг хэлээрээ:

Эзэн Есүс минь ээ, би үнэхээр гэмтэй гэдгээ хүлээн зөвшөөрж байна. Та миний бүхий л гэм нүглийг уучлаач. Би хийсэн бүх гэм нүглийнхээ төлөө харамсан Таны өмнө гэмшиж байна. Би Таныг өөрийн Аврагч мөн амьдралын минь Эзэн болгохыг хүсч байна. Есүсийн нэр дээр би залбирч байна. Амээн.